



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/138

Эрдэнэбулган сум

Аймгийн Эрүүл мэндийн газрын дүрэм,
үйл ажиллагааны чиглэл, бүтэц, орон
тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.3, 21.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны А/25, А/276, 2022 оны А/487, 2022 оны А/417 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 415 дугаар тушаалын 2 дахь хэсэг, 2020 оны А/37 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Эрүүл мэндийн газрын дүрмийг нэгдүгээр, аймгийн Эрүүл мэндийн газрын бүтцийг хоёрдугаар, үйл ажиллагааны чиглэлийг гуравдугаар, албан тушаалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн газрын дүрмээр тогтоосон үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах Эрүүл мэндийн газрын ажлын байрны орон тоог 47 хүнээр тогтоосугай.

3. Аймгийн Эрүүл мэндийн газрын шинэчлэн батлагдсан дүрэм, үйл ажиллагааны чиглэлийн дагуу орон тоо бүтцээ тогтоож, зохион байгуулалтыг боловсронгуй болгож нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Р.Гандиймаа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Эрүүл мэндийн газрын дүрэм, үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/743 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (И.Амартүвшин)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭННАДМИД

6513910429

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 24-ны өдрийн 43 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

- Аймгийн Эрүүл мэндийн газар (цаашид газар гэх)-ын бүрэн эрх чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

- Газар нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аймгийн Засаг даргын шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомж, стандартыг мөрдлөг болгоно.

- Газар нь иргэдээ дээдэлсэн, тэгш, хүртээмжтэй, чанартай, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмч эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангах, үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй ил тод, иргэдийн оролцоог хангасан байх зарчмыг баримтлана.

Хоёр. Үйл ажиллагааны чиглэл

Газар нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдох асуудлаар:

2.1.1. Өөрийн харъяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар хөтөлбөр, стратеги төлөвлөлт хийх, шийдвэр гаргахад аймгийн Засаг даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

2.1.2. Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх эрүүл мэндийн үйл ажиллагаанд бусад салбар, иргэдийн оролцоог хангах.

2.1.3. Хүн амын эрүүл мэндтэй холбогдон гарсан бодлого, хөтөлбөр, тушаал, шийдвэрийг өөрийн харъяа эрүүл мэндийн байгууллага болон орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага иргэдэд сурталчлан таниулж, хэрэгжилтийг зохион байгуулах.

2.1.4. Эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн түвшинд эмнэлгийн мэргэжилтэний баримтлах ёс зүйн хэм хэмжээг сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах.

2.1.5. Үйлчлүүлэгч төвтэй чанартай, аюулгүй, тусламж үйлчилгээг нэвтрүүлэх талаар онцгойлон анхаарч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, тусламж үйлчилгээтэй холбогдон гарсан иргэдийн санал, хүсэлт, гомдлыг барагдуулах, шийдвэрлэх.

2.2. Эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар:

2.2.1. Өөрийн харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар санал, дүгнэлт гаргах, тухайн шатны Засаг даргад танилцуулах, батламжлуулах.

2.2.2. Харъяа нутаг дэвсгэрийн хүн амынхаа эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, төрийн хүчин чадлаас давсан тусламж үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохицуулах, төлөвлөлт хийх.

2.2.3. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд өөрийн орон нутгаас тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллага болон төрийн тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт –шинжилгээ, үнэлгээ хийх.

2.3. Харъяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих чиглэлээр:

2.3.1. Эрүүл мэндийн байгууллагыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гарсан стандарт, тусламж үйлчилгээний багц, удирдамжийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.

2.3.2. Харъяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийн нөлөөг судлах судалгаа хийх, зөвлөмж гаргах.

2.3.3. Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах, хуваарилах.

2.3.4. Харъяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг санхүүгийн удирдлагаар хангах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн мэдээ, тайланг нэгтгэх, үнэлэлт, дүгнэлт өгөх.

2.4. Харъяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх асуудлаар:

2.4.1. Эрүүл мэндийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хүн амын эрүүл мэндийн талаар тулгамдаж буй асуудлыг тодорхойлоход шаардлагатай мэдээ, мэдээллээр холбогдох байгууллагуудыг цаг тухайд нь шуурхай хангах.

2.4.2. Өөрийн харъяа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас хүн амын өвчлөл, эндэгдлийн талаарх мэдээг цаг тухайд нь хүлээн авч нэгтгэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг эргэн мэдээллээр хангах.

Гурав. Удирдлага зохион байгуулалт:

3.1. Аймгийн Засаг дарга нь харъяалах нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн чанартай, аюулгүй, тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Төсвийн тухай хуулийн 6.6.3-д заасны дагуу эрх үүргээ Эрүүл мэндийн газрын даргад шилжүүлж болно.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч эрхээ шилжүүлэн ажилласнаар Төсвийн тухай хуулийн 22.6.5 заалтын дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.

3.3. Эрүүл мэндийн газар нь удирдлага, санхүү, аж ахуйн хувьд бие даасан ажиллах ба “Эрүүл мэндийн газар” гэсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга хэрэглэнэ.

3.4. Эрүүл мэндийн газар нь харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, санхүү хөрөнгө нөөцийг хуваарилах, хяналт тавих асуудлыг хариуцаж, Засаг дарга, Эрүүл мэндийн сайдын өмнө тайлагнана.

3.5. Газар нь холбогдох чиг үүргийн хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн төвийг арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллана.

3.6. Аймгийн Эрүүл мэндийн газрын орон тоог өөрийн орон нутгийн хүн ам, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнээс хамааруулан тогтоож, дүрэм үйл ажиллагааны чиглэлийг аймгийн Засаг даргын шийдвэрээр батлуулна.

Дөрөв. Эрх үүрэг

4.1. Эрүүл мэндийн газрын эрх: Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараах эрхийг эдэлнэ.

4.1.1. Харъяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн бүх эрүүл мэндийн байгууллагуудад хяналт-үнэлгээ, хяналт-шалгалт хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үүрэг, үүрэг даалгавар өгч биелэлтийг шалгах, хариуцлага тооцох.

4.1.2. Хүн амын эрүүл мэндийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд шаардлага тавих.

4.1.3. Өөрийн болон гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ хэлцэл хийх.

4.1.4. Өөрийн харъяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага, ажилтнуудыг үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, урамшуулан дэмжих чиглэлээр төр олон нийт, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, төрийн одон, медаль, салбарын болон нутгийн захиргааны байгууллагын шагналд нэр дэвшүүлэх **ШИЙДВЭРГЭХ**

4.2. Эрүүл мэндийн газрын үүрэг

4.2.1. Энэхүү дүрмийн 3.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн засаг дарга эрхээ шилжүүлсэн тохиолдолд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг нийгмийн эрүүл мэндийн дарга нартай байгуулсан гэрээний биелэлтийг аймгийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах,

4.2.2. Эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрх зүйн акт, стандарт, удирдамж, тусламж үйлчилгээний багц, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, шаардлагыг хэрэгжүүлэх,

4.2.3. Засаг даргаар ахлуулсан “Эрүүл мэндийн зөвлөл”-ийн ажлын албаны үүргийг гүйцэтгэж хурал зохион байгуулах, хэлэлцүүлэх асуудлыг нэгтгэн дүгнэх

4.2.4. Төр хувийн хэвшлийн хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран гүйцэтгэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийж, тэргүүлэх чиглэлээ тогтоож түншлэлийн чиглэл, хэтийн төлөвийг тодорхойлох.

4.2.5. Ядуу, эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг нэмэгдүүлэх ажлын зохион байгуулах

4.2.6. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх иргэд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тодорхой давтамжтайгаар авч мэдээлэх, судалгааны мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4.2.7. Албан бус төлбөрийг бууруулах, төлбөртэй тусламж үйлчилгээний үнэ тарифыг иргэдэд ил тод, нээлттэй байлгах арга хэмжээг зохион байгуулж хяналт тавих

4.2.8. Харьяагдах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй нөлөөллийн үнэлгээ болон эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн үнэлгээг холбогдох байгууллагатай хамтран хийж үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох дээд шатны байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх

4.2.9. Хүн амын өвчлөлийн чиг хандлага, эмнэлгийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулж өөрийн орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хийх, харьяа эрүүл мэндийн байгууллагын хөрөнгийн бүртгэлийн мэдээний санг байгуулах, тогтмол шинэчлэх

4.2.10. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн асуудлыг холбогдох хууль, эрз зүйн хүрээнд зохион байгуулах

4.2.11. Эм хангамжийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах

4.2.12. Харьяа эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээ, гүйцэтгэлийн гэрээний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

4.2.13. Харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг хүний нөөцөөр хангах үйл ажиллагааг орон нутагтаа зохион байгуулах

4.2.14. Өөрийн орон нутагт явуулж эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын орчинг бүрдүүлэх, сургалт зохион байгуулах нөхцөлөөр хангах

4.2.15. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээг зохион байгуулах

4.2.16. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа доголдлыг бүртгэн мэдээлэх

4.2.17. Холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох

4.2.18. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн зорилт стратеги тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, стратегийг нэгдсэн удирдлагаар хангаж хэрэгжилтийг зохион байгуулах


4.2.19. Зонхилон тохиолдох өвчлөл, түүний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах өөрийн харъяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийн талаар нөлөөллийн үнэлгээ хийх, хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх үйл ажиллагааг дангаараа болон бусад эмнэлэг мэргэжлийн төвүүд, салбар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран аймгийн хэмжээнд зохион байгуулах

4.2.20. Хүн амын дунд өвчлөлийг тандах, эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж эмчлэн эдгэрүүлэх үйл ажиллагааг харъяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах


4.2.21. Хүн амын дунд биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр чийрэгжих, эрүүл зөв хооллолтыг дэмжих, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр чийрэгжүүлэлтийн, хоол зүй, сэтгэл зүй, донтолт, хүчирхийллийн эсрэг зөвлөгөө өгөх болон өсвөр үе ахмадын эрүүл мэндийн нэгжийг байгуулан ажиллах

4.2.22. Халдварт болон халдварт бус өвчин, хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийн талаар тандалт судалгаа хийж, мэдээний сан байгуулан ажиллах.


Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 24-ны өдрийн 4/38
захирамжийн хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ҮЛГЭРЧИЛСЭН БҮТЭЦ



Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 24-ны өдрийн 738 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

барих, зөвхөн эрүүл
байчүүдийн эрүүл
хүний эрүүл мэнд
дэргэд тусламж
ийлчилгээ, сэргээн
дэргэд тусламж үйлчилгээ
үл мэндийн анхан
дэргэд тусламж
үйлчилгээ
Эм, эмнэлгийн
дэргэд хангамж,
дэргэд чанар аюулгүй
дэргэд, зохистой
дэргэд
дэргэд тусламж
үйлчилгээний чанар,
дэргэд, үнэлгээ
дэргэд тусламж,
дэргэд үеийн
дэргэд уулалт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭЛТЭС

- Эрүүл мэндийг дэмжих, салбар хоорондын зохицуулалт
- Эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээ, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал
- Халдварт өвчин, эмнэлгийн дотоод халдвар
- Дархлаажуулалт
- БЗДХ/ДОХ/ Сүрьеэгийн сэргийлэлт, тандалт
- Орчны эрүүл мэнд, эрүүл мэндийн нөлөөлөл
- Өсвөр үе, залуучуудын эрүүл мэнд
- Халдварт бус өвчний сэргийлэлт, эрт илрүүлэг
- Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт
- Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал
- Эрүүл мэндийн боловсрол сургалт сурталчилгаа

УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС

- Эрүүл мэндийн эдийн засаг, хөрөнгийн бүртгэл, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт
- Салбарын болон байгууллагын санхүүгийн бүртгэл, нягтлан бодох мэдээлэл
- Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл, эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал
- Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмж, барилгын чанар, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаа
- Хууль эрх зүй, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, эмнэлгийн мэргэжилтэний ёс зүй

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС

- Эмчилгээний хяналт
- Хүүхдийн эрүүл ахуйн хяналт
- Хүнсний эрүүл ахуйн хяналт
- Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналт
- Орчны эрүүл ахуйн хяналт


ДҮН ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТЭС

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит
- Эрүүл мэндийн статистик, мэдээ мэдээлэл
- Мэдээллийн технологи, эрүүл мэндийн мэдээний сан, зайн анагаах ухаан
- Хавдрын бүртгэл мэдээлэл

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА

Даргын туслах
Архив, бичиг хэрэг
Нярав
Жолооч
Үйлчлэгч
Цахилгаанчин
Сахиул

Аймгийн Засаг даргын 20.23-оны
 03-дугаар сарын 24-ны өдрийн 42-дугаар
 захирамжийн дөрөвдүгээр хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

№	Бүтцийн нэгж	Албан тушаалын тоо	Албан тушаалын зэрэглэл
	Дарга	1	T3-4
1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс		9	
1.1	Хэлтсийн дарга, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, үнэлгээ хариуцсан	1	T3-6
1.2	Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
1.3	Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
1.4	Гамшиг, яаралтай тусламж, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
1.5	Сувилахуй, ахмад настан, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
1.6	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
1.7	Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
1.8	Эмийн бодлого, хангамж, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
1.9	Эмийн дефектар	1	ТҮЭМ-4
2. Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс		12	
2.1	Хэлтсийн дарга, эрүүл мэндийг дэмжих, салбар хоорондын зохицуулалт, эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээ, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал хариуцсан	1	T3-6
2.2	Эрүүл мэндийн боловсрол, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
2.3	Орчны эрүүл мэнд, БЗДХ/ДОХ/ Сүрьеэгийн сэргийлэлт, тандалт хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
2.4	Өсвөр үе, залуучуудын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
2.5	Халдварт бус өвчний сэргийлэлт, эрт илрүүлэг хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
2.6	Халдварт өвчин, эмнэлгийн дотоод халдвар, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
2.7	Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн	1	ТҮЭМ-5

2.8	Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
2.9	Дархлаажуулалтын бага эмч	1	ТҮЭМ-4
2.10.	Өсвөр үеийн зөвлөгч бага эмч	1	ТҮЭМ-4
2.11	Өсвөр үеийн хүлээн авагч сувилагч	1	ТҮЭМ-3
2.12	Хэвлэл мэдээлэл, номын сан, сургалтын танхим хариуцсан ажилтан	1	ТҮ-5
3. Дүн шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс		6	
3.1	Хэлтсийн дарга, эрүүл мэндийн статистик, бүртгэл, мэдээлэл хариуцсан /улсын байцаагч/	1	T3-6
3.2	Эрүүл мэндийн хяналт, шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
3.3	Мэдээллийн технологич	1	ТҮ-7
3.4	Статистикч бага эмч, операторчин	2	ТҮЭМ-4
3.5	Хавдар бүртгэгч, операторчин	1	ТҮЭМ-4
4. Хяналт шалгалтын хэлтэс		5	
4.1	Хэлтсийн дарга, эмчилгээний хяналтын улсын ахлах байцаагч	1	T3-6
4.2	Хүүхдийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч	1	T3-7
4.3	Хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч	1	T3-7
4.4	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	1	T3-7
4.5	Орчны эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч	1	T3-7
5.Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс		5	
5.1	Хэлтсийн дарга, хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл, эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал хариуцсан	1	T3-6
5.2	Эрүүл мэндийн эдийн засаг, хөрөнгийн бүртгэл, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
5.3	Салбарын болон байгууллагын санхүүгийн бүртгэл, нягтлан бодох мэдээлэл хариуцсан мэргэжилтэн/ерөнхий нягтлан бодогч	1	ТҮ-8
5.4	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлт, хангалт, барилга, техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
5.5	Хууль эрх зүй, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, эмнэлгийн мэргэжилтэний ёс зүй, харилцаа хандлага хариуцсан мэргэжилтэн	1	T3-9
6.Үйлчилгээний алба /Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэст		9	

харъяалагдана/			
6.1	Даргын туслах, архивын эрхлэгч	1	ТҮ-5
6.2	Бичиг хэргийн ажилтан	1	ТҮ-2
6.3	Нярав	1	ТҮ-4
6.4	Жолооч	2	ТҮ-3
6.5	Үйлчлэгч	2	ТҮ-1
6.6	Цахилгаанчин, слесарь	1	ТҮ-3
6.7	Сахиул	1	ТҮ-1